

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АЙМГУУДАД

2016 ОНЫ 12-Р САР (Мониторингод нийт 21 аймгийн ЗДТГ хамрагдав.)

Шилэн дансны тухай хуулиар улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд 28 төрлийн мэдээллийг тодорхой хугацааны давтамжтайгаар нийтэд ил тод болгох ёстой. Эдгээрээс зургааг нь сонгон авч аймгуудын ЗДТГ 2016 оны 12 дугаар сард мэдээллээ хэрхэн ил тод болгосон байдлыг ажиглав.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ДҮН

ЗДТГ-ууд Төрийн санд бүртгэгдсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ХУДАЛДАН АВАЛТ, ГҮЙЛГЭЭНИЙ мэдээллээ бүрэн гүйцэд ил тод болгохгүй байна.

Энэ удаагийн мониторингод 21 аймгийн ЗДТГ-ын ил тод болгосон мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн 2016 оны 12 дугаар сарын дансны хуулгатай харьцуулж үзэв. Дүн мэдээгээр 12 дугаар сард зөвхөн 7 ЗДТГ Төрийн санд бүртгэгдсэн нийт гүйлгээнийхээ 50-иас дээш хувийг ил тод болгожээ. Өмнөговь, Орхон, Дундговь аймгуудын ил тод болгосон хувь харьцангуй өндөр байна. Харин Увс, Дархан-Уул аймгийн ЗДТГ Төрийн санд бүртгэгдсэн гүйлгээг огт нийтлээгүй байна.

100%

Өмнөговь

92.9%

Орхон

84.6%

Дундговь

66.7%

Дорнод

60.0%

Өвөрхангай, Хэнтий

50.0%

Төв

44.4%

Хөвсгөл

41.7%

Архангай

34.1%

Ховд

33.3%

Сүхбаатар

31.3%

Завхан

27.3%

Булган

25.0%

Говьсүмбэр, Сэлэнгэ

19.0%

Баянхонгор

18.5%

Дорноговь

16.0%

Говь-Алтай

9.4%


Баян-Өлгий

0%

Дархан-Уул, Увс

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээнд холбогдох ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ хангалтгүй байна.

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээнд холбогдох шийдвэрийн тоо



Орлого, зарлагын гүйлгээнд холбогдох шийдвэрийг ЗДТГ-уудын зөвхөн 24% буюу 5 нь нийтэлжээ. Орхон, Завхан, Дундговь, Сүхбаатар, Төв аймгуудын ЗДТГ цөөн тооны мэдээлэл нийтэлсэн бол бусад аймгуудын ЗДТГ огт нийтлээгүй байна.

5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийн тоо



Нийт ЗДТГ-уудын 71% буюу 15 нь 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт (хуулийн 6.4.4-р заалт)-ын мэдээлэл нийтэлжээ. Өвөрхангай аймгийн ЗДТГ хамгийн олон буюу 37 мэдээлэл нийтэлсэн бол Сүхбаатар, Өмнөговь, Дорнод, Говьсүмбэр, Баян-Өлгий, Архангай аймгуудын ЗДТГ огт мэдээлэл нийтлээгүй байна.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-уудын цахим хуудас
- ЗДТГ-уудын мэдээллийн самбар
- Сангийн яамны Төрийн сангийн дансны хуулга

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний тоо



Орлого, зарлагын гүйлгээ тус бүрийн мэдээллийг (хуулийн 6.4.5-р заалт) нийт ЗДТГ-уудын 90% буюу 19 нь нийтэлжээ. Говьсүмбэр аймгийн ЗДТГ хамгийн олон буюу 24 мэдээлэл нийтэлсэн бол Увс, Дархан-Уул аймгуудын ЗДТГ огт мэдээлэл нийтлээгүй байна.

29%

2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (хуулийн 6.1.1-р заалт)-г зөвхөн Хэнтий, Хөвсгөл, Ховд, Говь-Алтай, Булган, Баянхонгор аймгуудын ЗДТГ ил тод болгожээ.

ННФ-аас Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран мониторинг хийж дүнг сар бүр мэдээлж байна. Дүнг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.